



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/43

Хэрлэн сум

Мал эмнэлгийн арга
хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар заалт, аймгийн 2024 оны төсөв батлах тухай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ, уг өвчнөөс үүсэх гамшгийн үеийн бэлэн байдлыг хангахад шаардагдах зардалд 690,986,400 (зургаан зуун ерэн сая есөн зуун наян зургаан мянга дөрвөн зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Орон нутгийн төсөвт батлагдсан мал эмнэлгийн арга хэмжээний зардлын санхүүжилтийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, мал эмнэлгийн арга хэмжээний үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024
оны 01 дүгээр сарын 30-ны
... дугаар захирамжийн хавсралт

Аймгийн Засаг дарга
/төгрөгөөр/

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ БАТЛАГДСАН МАЛ ЭМНЭЛГИЙН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

№	Төрөл	Нийт
1	Тарилгын үйлчилгээний зардал	315,000,000
2	Шинжилгээний үйлчилгээний зардал	3,200,000
3	Вакцины үнэ	306,343,800
4	Хөдөлмөр хамгааллын хувцас	19,980,000
5	Машин, тоног төхөөрөмж	19,910,000
6	Лаборатори /Багаж, тоног төхөөрөмж/	10,000,000
7	Лабораторийн оношлуур, эм урвалж	9,600,000
8	Хяналтын зардал	6,952,600
	Дүн	690,986,400